



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 1/68

Шивээговь сум

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/147 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Төрөөс баримталж буй бодлого шийдвэр, бүх шатанд ажлын хариуцлага сахилгыг өндөржүүлэх, санаачилгыг өрнүүлэх, иргэдэд үйлчлэх, төрийн үйлчилгээнд чанарын ахиц дэвшил гаргах, бодлогын зорилтууд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулах чиглэлээр сумын хэмжээнд хяналт шалгалтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

(Мэдээ мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтан)

(Архив, бичиг хэргийн эрхлэгч)

(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

3. Хяналт шалгалт хийх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Ажлыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, үр дүнг дүгнэн зохих арга хэмжээг авч ажиллан тайлгахыг нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П. ГАНЧИМЭГ



Сумын Засаг даргын 2023 оны
05-р сарын 18-ны өдрийн 11/08 дугаар
захирамжийн хавсралт



**“Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд
хяналт шинжилгээ үнэлгээ” хийх ажлын удирдамж**

2023.05.18

Шивээговь сум

Нэг. Зорилго: Суманд хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төлөвлөлт, эзэнжүүлэлт, хэрэгжилт, байгууллагын дарга нарын шийдвэрийн хуулийн үндэслэл, аймаг сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтийн биелэлт үр дүнд хүрч хэрэгжиж байгаа эсэх, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлтүүдэд хяналт шинжилгээ хийж зөвлөн тусалж, зөвлөмжөөр хангах, дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт шалгалт хийх үндэслэл: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/150 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” зэрэг нь эрх зүйн үндэс болно.

Гурав. Хамрах хүрээ: Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, 3 дугаар цэцэрлэг, Соёлын төв, Илчлэг Шивээ ОНӨААТҮГ

Дөрөв. Хугацаа: Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсэг 2023 оны 05 дугаар сарын 31-нээс 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд байгууллагын үйл ажиллагаатай танилцан үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 06 дүгээр сарын 05-ны дотор зөвлөмжийг хүргүүлэн ажиллана.

Тав. Зохион байгуулагч: Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын ЗДТГ

Зургаа. Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд:

1. Байгууллагуудын үйл ажиллагаа, тушаал шийдвэр, бичиг баримтын стандарт
2. Байгууллагын хэтийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт
3. Санхүүгийн ил тод байдал

4. Шинээр санаачлан хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, орчны тохижилт
5. Иргэдийн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлт
6. Эмчлүүлэгчдийн хоол, цэцэрлэгийн хүүхдийн хоол, “Үдийн цай” хөтөлбөр батлагдсан төсөв норм
7. Дотуур байр болон анги танхимын тохижилт, ариутгал халдвартгуйжүүлэлт
8. Эд хөрөнгө болон тоног төхөөрөмжийн ашиглалт бүрэн бүтэн байдал
9. Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт
10. Төрийн албан хаагчдын сургалт хөтөлбөрийн хэрэгжилт
11. Төрийн албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт
12. Төрийн албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл
13. 14 хоногийн мэдээ өгсөн байдал
14. Үүрэг даалгаврын биелэлт, тайлагналт
15. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт
16. Мэдээллийн ил тод байдал

Долоо. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний хуудас

1	2	Үзүүлэлт		үр дүнгийн үнэлгээ	
		Хувь	Оноо	3	4
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, албан даалгаврын хэрэгжилт	100		5	
	Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөлт, эзэнжүүлэлт, хэрэгжилт	100		5	
	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт	100		5	
	Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	100		5	
	Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт	100		5	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Үнэлгээний дундаж оноо	100	5		
	Засаг даргатай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	100		5	
	2. Байгууллагын хэтийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт				
	Албан хаагч тус бүр хувийн /хувийн хэрэг нээж, хөтөлсөн эсэх/ хэрэг, нээж төрөлжүүлсэн, ангилсан, баяжилт хийсэн эсэх.	100		5	

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Төрийн албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг байгуулж баталгаажуулсан байдал, гэрээний дүгнэлт	100	5
	Төрийн албан хаагчдын “Сургалт хөтөлбөр”-ийн хэрэгжилт	100	5
	Төрийн албан хаачдын “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилт	100	5
	Дотоод эрх зүйн сургалтын төлөвлөгөө, хэрэгжилт	100	5
	8. Иргэдийн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлт	100	5
	Байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарын тушаал шийдвэрийн үндэслэл, стандарт	100	5
	9. Шинээр санаачлан хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, орчны тохижилт	100	5
	1. Сумын удирдлагаас өгсөн үүргийн биелэлт	100	5
	2. Корона вирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, нөөц		
	Үнэлгээний дундаж оноо	100	5
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайлан	100	5
	2. Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан мэдээлэл, иргэдэд нээлттэй ил тод байлгасан байдал	100	5
	3. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	100	5
	4. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, хяналт шалгалтын байгууллагаар зөрчилгүй дүгнэгдсэн байдал	100	5
	5. Аудитын зөвлөмжийн хэрэгжилт	100	5
	6. Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл	100	5
	7. Өр авлагыг бууруулах талаар авч хэрэгжүүлэж буй арга хэмжээ	100	5
	8. Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт	100	5
Үнэлгээний дундаж оноо		100	5
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ:		100	5

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Найм. “Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ” хийх хуваарь

№	Шалгалтанд хамрагдах байгууллага	Хугацаа	Комиссын бүрэлдэхүүн
1.	Эрүүл мэндийн төв	2023.05.31.	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2.	Илчлэг Шивээ ОНӨААТҮГ	2023.05.31.	
3.	Соёлын төв	2023.05.31.	
4.	З дугаар цэцэрлэг	2023.06.02.	
5.	Ерөнхий боловсролын сургууль	2023.06.02.	